



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/586

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2023 оны хамтран ажиллах гэрээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хүүхдийн жаргалант зуслангийн гадна тохижилт, дулаан механик, сантехник, дотор заслын ажлыг 569,600,000 (таван зуун жаран есөн сая зургаан зуун мянга) төгрөгөөр “Эрдэнэс эко үүр” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)/-т олгосугай.


2.Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Эрдэнэс эко үүр” ХХК-ийн захирал (Д.Нарантулга)-д үүрэг болгосугай.

3.Булган аймгийн хүүхдийн жаргалант зуслангийн гадна тохижилт, дулаан механик, сантехник, дотор заслын ажилд хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Тус ажлыг Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2023 оны хамтран ажиллах гэрээний 9 дэх заалтад тусгагдсан төсөл арга хэмжээнээс 325,600,000 (гурван зуун хорин таван сая зургаан зуун мянга) төгрөгөөр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.16 дахь заалтад тусгагдсан төсөл арга хэмжээнээс 244,000,000 (хоёр зуун дөчин дөрвөн сая) төгрөгөөр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6323010620